

**НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ**

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	<b>Нэр</b> Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Бадарчийн Нармандах
2	<b>Хүсэлт гаргагчийн хаяг</b> Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	<b>Төрсөн огноо</b> Төрсөн газар	
4	<b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- МУИС-ийн ХЗС-ийн докторантур /2003-2012/, хууль зүйн доктор</li> <li>- МУИС-ийн ХЗС-ийн магистрантур /1999-2000/, хууль зүйн магистр</li> <li>- Цагдаагийн дээд сургууль /1995-1999/, эрх зүйч, бакалавр</li> <li>- Цэцэрлэгийн багшийн сургууль /1990-1993/, хүмүүжүүлэгч багш</li> </ul>
5	<b>Ажил эрхлэлт</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- ТЕГ-ын Тамгын газрын Захиргаа эрх зүйн хэлтсийн дарга /2018-2020/, <a href="http://www.gia.gov.mn">www.gia.gov.mn</a>, 92263656</li> <li>- ТЕГ-ын Тамгын газрын Захиргаа эрх зүйн хэлтсийн ахлах ажилтан /2016-2018/, <a href="http://www.gia.gov.mn">www.gia.gov.mn</a>, 92263656</li> <li>- Үндэсний тагнуулын академид эрх зүйн тэнхимийн эрхлэгч, дэд профессор /2014-2016/, 92263502</li> <li>- Цагдаагийн академи, Дотоод хэргийн Их сургууль, Хууль сахиулахын их сургуульд тэнхимийн эрхлэгч /2009-2014/ <a href="http://www.uia.gov.mn">www.uia.gov.mn</a>, 70155026</li> <li>- Цагдаагийн академид ахлах багш /2007-2009/</li> <li>- Цагдаагийн дээд сургууль, Цагдаагийн академид багш /1999-2007/</li> <li>- БЗД-ийн 62, 129 дүгээр цэцэрлэгт багш /1993-1997/</li> </ul>
6	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

7	<p><b>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил</b> Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолт;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</li> </ul>	<p>1. ТЕГ-ын Тамгын газрын Захиргаа эрх зүйн хэлтсийн дарга /2018-2020/, ТЕГ-ын Тамгын газрын Захиргаа эрх зүйн хэлтсийн ахлах ажилтан /2016-2018/, Үндэсний тагнуулын академид эрх зүйн тэнхимийн эрхлэгч, дэд профессор /2014-2016/</p> <p>2. Цагдаагийн академи, Дотоод хэргийн Их сургууль, Хууль сахиулахын их сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч /2009-2014/</p> <p>-</p>
8	<p><b>Ёс зүй</b> Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> <li>-сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх;</li> <li>-сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.</li> </ul>	<p>Үгүй.</p>
9	<p><b>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар</b> Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Алсын хараа-2050 бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэрэгт дэд ажлын хэсгийн даргаар ажиллаж, 2020.05.13-ны өдөр УИХ-аас батлуулсан.</li> <li>- Байгууллагын дотоод журам, зааврыг Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажилласан.</li> <li>- Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүйч мэргэжлийн профессорын багийн профессор, зөвлөх профессороор 2012 оноос одоог хүртэл ажиллаж байна.</li> <li>- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр 2016 оноос ажиллаж байна.</li> <li>- Монголын Хуульчдын холбооны гишүүн, сургагч багшаар 2010 оноос хойш ажиллаж, Хүний эрх, Үндсэн хуулийн эдийн засаг, Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ зэрэг сэдвүүдээр төв, орон нутгийн нутгийн захиргааны байгууллага, Өмгөөлөгчдийн холбоо, бусад төрийн захиргааны байгууллагуудад хичээл тогтмол зааж байсан.</li> <li>- “Нийтийн эрх зүйн хэм хэмжээний хэрэглээ, анхаарах зарим асуудал” онол практикийн бага хурлыг 2014 онд, “Хууль сахиулах байгууллагуудын захиргааны үйл ажиллагаа ба эрх зүйн шинэтгэлийн зарим асуудал” эрдэм шинжилгээний бага хурлыг 2013 онд, Захиргааны хяналт: үр нөлөө, боловсронгуй болгох зарим асуудал эрдэм шинжилгээний бага хурлыг 2011 онд тус тус хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулж байсан.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Хууль зүйн их дээд сургуулиудад 17 жил Үндсэн хуулийн эрх зүй, Хүний эрх, Захиргааны эрх зүйн чиглэлээр багшилсан, хүний эрхийн чиглэлээр мэргэшин судалгаа хийж, 2012 онд МУИС-ийн ХЗС-ийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн шийдвэрээр “Монгол Улс дахь хүний эрх, түүнийг хангах эрх зүйн механизмыг боловсронгуй болгох зарим асуудал” сэдвээр хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.</li> </ul>
10	<p><b>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил</b>  Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолт;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ТЕГ-ын ТГ-ын ЗЭЗХ-т ахлах ажилтан, хэлтсийн даргаар ажиллаж, байгууллагын дотоод журам, эрх зүйн баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэх, Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөгжлийн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагын үйл ажиллагаа нь хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэхэд чиглэсэн эсэхэд хяналт тавих, хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлэх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.</li> <li>- ТЕГ-ын эмэгтэй албан хаагчдын эрх ашгийг төлөөлөх Мандухай зөвлөлийн Нарийн бичгийн даргаар 2018-2019 онд ажиллаж, эмэгтэй албан хаагчдын эрх ашгийг хангахад чиглэсэн зарим шийдвэрийг гаргуулсан. Тухайлбал, Эмэгтэй цэргийн албан хаагчдад хүүхэд асрах чөлөөтэй байх үед цолны мөнгө олгох, эмэгтэйчүүдийг мэргэжлийн болон хүний хөгжлийн чиглэлийн сургалт, семинарт хамруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажилласан.</li> <li>- ХСИС-д ажиллаж байх үедээ 4 жил дараалан олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан хүний эрхийг сурталчлах, хөхиүлэн дэмжих арга хэмжээг хүний эрхийн төрийн бус байгууллагууд болон ХЭҮК-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж ажилласан.</li> <li>- ХЭҮК-оос Цагдаагийн академид байгуулж өгсөн Хүний эрхийн сургалтын төвийн эрхлэгчээр 3 жил ажиллаж, хууль сахиулах салбарын хүний нөөцийг хүний эрхийн мэдлэг, чадвар, хандлагатай болгох сургалт, дадлагыг зохион байгуулж ажилласан.</li> <li>- Эрх зүйн бакалаврын сургалтын төлөвлөгөөнд багтсан Хүний эрх хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байсан. Жишиг хөтөлбөрийн дагуу хүний эрх хичээлийг 10 орчим жил бакалавр, магистр, докторын сургалтад заасан.</li> <li>- Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын уулзалт, семинар, сургалт, судалгааны ажилд тогтмол хамрагдаж ирсэн.</li> <li>- Хүний эрхийг сурталчлах зурагт хуудас, брошуур бэлтгэж хууль сахиулах байгууллагуудад тарааж байсан.</li> </ul>
11	<p><b>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал</b>  Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны ажлын чиглэлээр шүүх эрх мэдэл ба хүний эрх, Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зарим асуудал, Цагдаагийн албан хаагчийн авулгүй байдал, эрх зүйн баталгаа зэрэг сэдвээр 3 магистрын судалгааны ажлын удирдагчаар ажилласан.</li> </ul>

	<p>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;</p> <p>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	
12	<p><b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар</b></p> <p>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <p>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</p> <p>-ажлын байрны тодорхойлолт;</p> <p>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</p> <p>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл</p> <p><b>Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</b></p>	-
13	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b></p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.</p>	<p>- Монголын Хуульчдын холбооны гишүүн</p> <p>- МХХ-ны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны гишүүн.</p>
14	<b>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн</b>	- Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, сурах бичиг, 2003, 2006, 2011, 2017.

<p><b>мэдээлэл</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын нийтийн эрх зүй /хамтын бүтээл/, гарын авлага, 2010</li> <li>- Хүний эрх: хүний эрхийн ойлголт, үндсэн асуудлууд, нэг сэдэвт бүтээл, 2009</li> <li>- Олон улсын нийтийн эрх зүйн зарим нэр томъёоны тайлбар /хамтын бүтээл/, 2010</li> <li>- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн эргэн тойронд ... /баримт биичиг, өгүүлэл нийтлэл, бусад мэдээллийн эмхэтгэл/ нэгдүгээр дэвтэр, 2017</li> <li>- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн эргэн тойронд ... /баримт биичиг, өгүүлэл нийтлэл, бусад мэдээллийн эмхэтгэл/ хоёрдугаар дэвтэр, 2017</li> <li>- О классификации прав и свобод человека в Монголии, Деятельность правоохранительных органов и государственной противопожарной службы в современных условиях: проблемы и перспективы /Международной научно-практической конференции/, Иркутск, 2010</li> <li>- Өдрийн сонин 2014. Монгол Улсын Үндсэн хуулийн түүхэн хөгжил, ач холбогдол ярилцлага.</li> </ul>
--	---

--- оОо ---